

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Алтай орон сууцны корпорац ААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/002/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Цэрэнханд Утас: 99086371 Цахим хаяг: tserenkhandd@audit.gov.mn Аудитор: С.Санчирмаа Утас: 99282488 Цахим хаяг: sanchirmaas@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГАА-2025/002/НА-СТА-ОНӨҮГ



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН АЛТАЙ
ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦЫН
ЗАХИРАЛ Д.НАРАНЧИМЭГ ТАНАА

2025.03.15 № 108

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Алтай орон сууцны корпорацын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1, 41.2.7, Төрийн түрээсийн орон сууцанд орон сууц түрээслэх гэрээний 3 дугаар зүйлийн 3.2, Үл хөдлөх хөрөнгө зээлээр худалдах, худалдан авах гэрээний 2 дугаар зүйлийн 2.3 дэх зүйлтэй нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Гэрээнд заасан хуваарьт хугацаанд 221,218.7 мянган төгрөгийн үндсэн төлбөр, 8,920.4 мянган төгрөгийн түрээсийн төлбөрийг төлүүлээгүй,
- Монгол Улсын Хөгжлийн банканд төлөх хуваарийг тогтоохдоо түрээслэгчээс авах жил бүрийн орлогын эх үүсвэрийг харгалзаж тооцоогүй, хүүг төлөх асуудлыг шийдвэрлээгүй зэргээс шалтгаалж 2024 онд орон сууцны үндсэн төлбөрийн 5,608,554.7 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байна.

8225020309

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант хугацаанд 2 өрхөд байрыг нь өмчлүүлж, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг гаргуулсан байна.

Есөнбулаг сумын Баянхайрхан багийн Солонго хороололд хувийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа орон сууцны барилга угсралтын ажилд гуравласан гэрээний үндсэн дээр захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлж, 25,200.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлжээ.

Солонго хорооллын түрээсийн 120 айлын орон сууцны барилгын 2/68 дугаартай “Үл хөдлөх эд хөрөнгө зээлээр худалдах худалдан авах гэрээ”-г Монгол Улсын Хөгжлийн банк, аймгийн Засаг даргатай 2020 оны 8 дугаар сарын 21-ний өдөр байгуулсан. Тус гэрээний 2.3 дахь заалтыг хэрэгжүүлэх талаар хүсэлт хүргүүлснээр аймгийн Засаг даргын 2024 оны А/228 дугаар захирамжаар зээлийн хүүгийн төлбөрт 25,000.0 мянган төгрөгийг шийдвэрлүүлж, Монгол Улсын Хөгжлийн банканд шилжүүлсэн байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 26 дугаар тогтоолоор нэг орон тоо нэмэгдэж, 6.0 хувиар цалин хөлсийг нэмэгдүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Хөгжлийн банканд төлөх хуваарийг тогтоохдоо түрээслэгчээс авах жил бүрийн орлогын эх үүсвэрийг харгалзаж тооцоогүй, хүүг төлөх асуудлыг шийдвэрлээгүй зэргээс шалтгаалж 2024 онд орон сууцны үндсэн төлбөрийн 5,608,554.7 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд тус байгууллагын төсөв захирагч 5 зорилт, 33 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, аймгийн Засаг даргаас биелэлтийг 97.3 хувиар дүгнэсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	6,713,021,460.04	6,181,677,568.41
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	355,046,811.91	509,828,670.90
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	355,046,811.91	509,828,670.90
31210	Төгрөг	355,046,811.91	509,828,670.90
31213	Арилжааны банк дахь харилцах	355,046,811.91	509,828,670.90
33	АВЛАГА	6,175,295,988.13	5,489,000,237.51
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	138,688.47	-
33401	Дансны авлага /ТӨҮГ/	3,973,097,234.00	2,759,307,012.00
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	-	4,749,366.68
33500	Бусад авлага	2,202,060,065.66	2,724,943,858.83
33510	Байгууллагаас авах авлага	2,202,060,065.66	2,724,943,858.83
35	БАРАА МАТЕРИАЛ	2,678,660.00	2,848,660.00
35400	Хангамжийн материал	2,678,660.00	2,848,660.00
35420	Аж ахуйн материал	2,678,660.00	2,848,660.00
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	180,000,000.00	180,000,000.00
36900	БЗЭБуй эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	180,000,000.00	180,000,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	73,939,289.96	265,149,054.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	73,939,289.96	265,149,054.00
39200	Биет хөрөнгө	15,606,289.96	14,576,054.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	7,223,940.00	7,373,940.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(2,322,040.12)	(2,892,451.00)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,249,390.00	13,249,390.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(2,544,999.92)	(3,154,825.00)
39300	Биет бус хөрөнгө	58,333,000.00	250,573,000.00
39301	Программ хангамж	2,730,000.00	2,730,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(637,000.00)	(637,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	56,240,000.00	248,480,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,786,960,750.00	6,446,826,622.41
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	6,354,045,151.52	5,789,615,168.47
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	284,462,925.43	181,060,402.47
41300	Өглөг	2,647,190.64	1,776,770.82
41360	Бусад өглөг	2,647,190.64	1,776,770.82
41361	Байгууллагад төлөх өглөг	593,208.00	1,594,771.00
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	2,053,982.64	181,999.82
41400	Урьдчилж орсон орлого	281,815,734.79	179,283,631.65
41420	Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	166,637,212.00	162,416,682.00
41440	Бусад урьдчилж орсон орлого	115,178,522.79	16,866,949.65
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,069,582,226.09	5,608,554,766.00
42200	Урт хугацаат зээл	6,069,582,226.09	5,608,554,766.00
42210	Төгрөг	6,069,582,226.09	5,608,554,766.00

Говь-Алтай аймгийн Алтай орон сууцны корпорац ААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

42243	Санхүүгийн бусад байгууллага /ТӨҮГ/	6,069,582,226.09	5,608,554,766.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	432,915,598.48	657,211,453.94
51	Засгийн газрын хувь оролцоо	432,915,598.48	657,211,453.94
51200	Хуримтлагдсан үр дүн	432,915,598.48	657,211,453.94
51210	Өмнөх үеийн үр дүн	1,627,740,080.58	432,915,598.48
51220	Тайлант үеийн үр дүн	(1,194,824,482.10)	224,295,855.46
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,786,960,750.00	6,446,826,622.41

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	260,154,308.00	418,012,150.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	260,154,308.00	418,012,150.00
120	Нийтлэг татварын бус орлого	260,154,308.00	418,012,150.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	97,851,981.00	46,514,421.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	97,851,981.00	46,514,421.00
120005	Түрээсийн орлого	81,216,254.00	84,543,994.00
120009	Бусад орлого	42,039,238.00	55,666,900.00
120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	39,046,835.00	39,046,835.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	192,240,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	180,978,790.10	193,716,294.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	180,978,790.10	193,716,294.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	180,978,790.10	193,716,294.54
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	180,978,790.10	193,716,294.54
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	180,978,790.10	193,716,294.54
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	79,175,517.90	224,295,855.46
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	2,500,000.00	-
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	2,500,000.00	-
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,276,500,000.00	-
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	1,276,500,000.00	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(1,194,824,482.10)	224,295,855.46

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	818,917,262.00	1,297,216,833.31
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	818,917,262.00	1,297,216,833.31
120	Нийтлэг татварын бус орлого	818,917,262.00	1,297,216,833.31
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	693,871,770.00	1,165,148,047.31
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	693,871,770.00	1,165,148,047.31
120005	Түрээсийн орлого	73,935,254.00	76,401,886.00
120009	Бусад орлого	51,110,238.00	55,666,900.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	177,897,075.14	183,263,395.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	177,897,075.14	183,263,395.32

Говь-Алтай аймгийн Алтай орон сууцны корпорац ААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	177,897,075.14	183,263,395.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	94,899,642.87	114,925,544.00
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	94,899,642.87	114,925,544.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,289,419.77	25,584,448.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	26,289,419.77	25,584,448.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,279,682.00	8,787,607.50
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	8,279,682.00	8,787,607.50
2104	Хангамж, бараа материалын зардал	7,184,290.00	6,021,850.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	2,307,550.00	1,448,900.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	4,876,740.00	4,572,950.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	41,244,040.50	27,943,945.82
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	29,193,746.46	22,119,973.68
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	12,050,294.04	5,823,972.14
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	641,020,186.86	1,113,953,437.99
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	154,351,981.00	46,514,421.00
140001	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	56,500,000.00	-
140007	Хүлээн авсан хүүний орлого	97,851,981.00	46,514,421.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,201,155,600.00	1,005,686,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,201,155,600.00	1,005,686,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,201,155,600.00	1,005,686,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,155,600.00	150,000.00
225105	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа /ТӨҮГ/	1,200,000,000.00	1,005,536,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(1,046,803,619.00)	(959,171,579.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(405,783,432.14)	154,781,858.99
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	760,830,244.05	355,046,811.91
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	355,046,811.91	509,828,670.90

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,627,740,080.58	1,627,740,080.58
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	1,627,740,080.58	1,627,740,080.58
Тайлант үеийн үр дүн	-	-	(1,194,824,482.10)	(1,194,824,482.10)
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	432,915,598.48	432,915,598.48
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	432,915,598.48	432,915,598.48
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	432,915,598.48	432,915,598.48

Тайлант үеийн үр дүн	-	-	224,295,855.46	224,295,855.46
2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	-	-	657,211,453.94	657,211,453.94

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Орон сууцны борлуулалтын орлого	39,046,835.00	39,046,835.00	-	100.00
Техник хяналтын орлого	22,000,000.00	25,200,000.00	(3,200,000.00)	114.55
Түрээсийн орлого /Граж/	5,500,000.00	8,605,000.00	(3,105,000.00)	156.45
Түрээсийн орлого /орон сууц	60,000,000.00	76,188,994.00	(16,188,994.00)	126.98
Хадгаламжийн болон харилцах дансны хүүгийн орлого	24,000,000.00	46,514,421.00	(22,514,421.00)	193.81
Сууц эзэмшигчийн үйлчилгээний хураамж	14,400,000.00	14,180,000.00	220,000.00	98.47
Бусад орлого	5,120,000.00	8,481,900.00	(3,361,900.00)	165.66
ОРЛОГО	170,066,835.00	218,217,150.00	(48,150,315.00)	128.31
1.3 Нийт ашиг	170,066,835.00	218,217,150.00	(48,150,315.00)	128.31
Үндсэн үйл ажиллагааны зардал	162,883,100.00	189,101,769.00	(26,218,669.00)	116.10
1.4.20 Үйл ажиллагааны зардлын дүн	162,883,100.00	189,101,769.00	(26,218,669.00)	116.10
1.5 Үндсэн үйл ажиллагааны ашиг /алдагдал/	7,183,735.00	29,115,381.00	(21,931,646.00)	405.30
3. Татвар төлөхийн өмнөх ашиг алдагдал	7,183,735.00	29,115,381.00	(21,931,646.00)	405.30
Татвар төлөх ашиг алдагдал	7,183,735.00	29,115,381.00	(21,931,646.00)	405.30
3.1 Орлогын татварын зардал		2,911,538.10	(2,911,538.10)	-
4. Татварын дараах ашиг алдагдал	7,183,735.00	26,203,842.90	(19,020,107.90)	364.77

Гурав. Аудитын илрүүлэлт:

3.1 Залруулсан алдаа

Аудитаар 4,614.5 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:

- Санхүүгийн байдлын тайланд 4,614.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг зөрүүтэй тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн

6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 230,139.1 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 230,139.1 мянган төгрөгийн 2 зөрчил² илэрсэнд 230,139.1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1 заалт арилгах албан шаардлага хүргүүлсэн.

3.2 Төлбөрийн акт

1. Гэрээнд заасан хуваарьт хугацаанд 221,218.7 мянган төгрөгийн үндсэн төлбөр, 8,920.4 мянган төгрөгийн түрээсийн төлбөрийг төлүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх"; Төрийн түрээсийн орон сууцанд орон сууц түрээслэх гэрээний 3.2-т "Гэрээний хавсралтад заасан төлбөр төлөлтийн хуваарийн дагуу төлбөрийг 2 сар төлөөгүй тохиолдолд сануулах ба 3 сараас дээш хугацаагаар төлөөгүй тохиолдолд түрээслээд өмчлөгчтэй байгуулсан гэрээг цуцалж энгийн түрээсээр тооцож хуримтлуулсан урьдчилгаанаас тооцож авна" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн төлбөр, түрээсийн төлбөрийг төлүүлж харилцах дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

3.3 Албан шаардлага

1. Монгол Улсын Хөгжлийн банканд төлөх хуваарь нь түрээслэгчээс авах жил бүрийн орлогын эх үүсвэрийг харгалзаж тооцоогүй, хүүг төлөх асуудлыг шийдвэрлээгүй, түрээслэгчээс төлсөн төлбөрийг дутуу төвлөрүүлсэн зэргээс шалтгаалж 2024 онд орон сууцны үндсэн төлбөрт 5,608,554.7 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7-т "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Үл хөдлөх эд хөрөнгө зээлээр худалдах, худалдан авах гэрээний 2.3-т "Худалдан авагч зээлээр худалдан авсан үл хөдлөх хөрөнгийн үнийг Гэрээний Хавсралт 2-т тусгасан хуваарийн дагуу төлөөгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн дүнгийн 0.3 хувиар тооцож, алданги ногдуулна" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Эдийн засгийн тооцоо судалгаа хийж Монгол Улсын Хөгжлийн банканд төлөх хугацаа хэтэрсэн зээлийг шийдвэрлэх арга хэмжээ авах албан шаардлага хүргүүлсэн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Говь-Алтай аймгийн Алтай орон сууцны корпорац	Санхүүгийн байдлын тайланд 4,614.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг зөрүүтэй тайлагнасан.	1	4,614.5	-	-	1	4,614.5	1	4,614.5	-	-	-	-
Дүн		1	4,614.5	-	-	1	4,614.5	1	4,614.5	-	-	-	-

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл /мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Говь-Алтай аймгийн Алтай орон сууцны корпорац	Гэрээнд заасан хуваарьт хугацаанд 221,218.7 мянган төгрөгийн үндсэн төлбөр, 8,920.4 мянган төгрөгийн түрээсийн төлбөрийг төлүүлээгүй.	1	230,139.1	1	230,139.1	-	-	-	-	-	-
	Монгол Улсын Хөгжлийн банканд төлөх хуваарь нь түрээслэгчээс авах жил бүрийн орлогын эх үүсвэрийг харгалзаж тооцоогүй, хүүг төлөх асуудлыг шийдвэрлээгүй зэргээс шалтгаалж 2024 онд орон сууцны үндсэн төлбөрт 5,608,554.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.	1	-	-	-	-	1	-	-	-	-
Дүн		2	230,139.1	1	230,139.1	1	-	-	-	-	

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
	НИЙТ	1	1				1		